



МОНГОЛ УЛСЫН  
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2020 оны 4 сарын 27 өдөр

Дугаар 39

Улаанбаатар хот

“ШИНЭ нам, Бүгд найрамдах нам,  
Үнэн ба зөв нам, Монгол үндэсний ардчилсан намын ШИНЭ ЭВСЭЛ”-ийг  
Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд  
оролцуулахаар бүртгэх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2, 28.3, 28.6 дахь хэсэг, Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооноос ТОГТООХ нь:

1.”ШИНЭ нам, Бүгд найрамдах нам, Үнэн ба зөв нам, Монгол үндэсний ардчилсан намын ШИНЭ ЭВСЭЛ”-ийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцуулахаар бүртгэсүгэй.

2.Монгол Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцуулахаар бүртгэсэн тул “ШИНЭ нам, Бүгд найрамдах нам, Үнэн ба зөв нам, Монгол үндэсний ардчилсан намын ШИНЭ ЭВСЭЛ”-д батламж олгосугай.

ДАРГА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



Ч.СОДНОМЦЭРЭН

Ц.БОЛДСАЙХАН